



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Ардчилсан намын үндсэн дүрэмд оруулсан  
нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх  
өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан намаас гаргасан тус намын үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг.Өргөдөл гаргагч С.Эрдэнэ, Д.Ганбат, Ч.Өнөрбаяр нараас "...Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолд дурдсан зөрчлийг арилгах үүднээс үндсэн дүрмийн 9 дүгээр бүлгийн 9.1.1 дэх заалтыг баримтлан Ардчилсан намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тус намын Үзэл баримтлал, үндсэн дүрмийн зөвлөлөөс гаргасан саналын дагуу Үндэсний бодлогын хорооны 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг намын ээлжит бус XIII Их хуралд өргөн барьсан. 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр намын ээлжит бус XIII Их хурлаар үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэн баталж, Улсын дээд шүүхийн тогтоолд заасан зөрчлийг арилган, бүртгүүлэхээр дахин хүргүүлж байна" гэх өргөдөл гаргаж, өргөдөлдөө:

-Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл, (1 хуудас)

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 1 хувь,  
- Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөг тушаасан баримт (1 хуудас),  
- Үндсэн дүрмийн зөвлөлийн Ардчилсан намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал (1хуудас)

- Ардчилсан намын Үзэл баримтлал, үндсэн дүрмийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэл (3 хуудас)

- Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоол (1 хуудас)

- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоол (4 хуудас)
- Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн “Ардчилсан намын ээлжит бус XIII Их Хурлын төлөөлөгчдийн мандатын тоо батлах тухай” 01 дүгээр тогтоол (1 хуудас)
- Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дугаартай хурлын тэмдэглэл (1 хуудас)
- Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Санал хураалтын тов тогтоох зохион байгуулах тухай” 02 дугаартай тогтоол (1 хуудас)
- Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаартай хурлын тэмдэглэл (1 хуудас)
- Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын төлөөлөгчдийг өргөн мэдүүлэх тухай” 03 дугаартай тогтоол (1 хуудас)
- Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03 дугаартай хурлын тэмдэглэл (1 хуудас)
- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хуралд оролцох төлөөлөгчдийн цахим сонгуулийн дүн (27 хуудас)
- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Намын ээлжит бус XIII Их хурал хуралдсан тухай” 01 дугаартай тэмдэглэл (15 хуудас)
- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын тооллогын комиссын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Ардчилсан намын үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батламжлах тухай” 01 дүгээр тогтоол (1 хуудас),
- Хоёр.С.Эрдэнээс 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 24 дугаартай албан бичигт “Бүрдүүлбэр материал хүргүүлэх тухай” гээд,
- Ардчилсан намын 2022 оны 03 дугаар сарын 05-ны ээлжит бус XIII Их хуралд оролцсон төлөөлөгчдийн бүртгэл (19 хуудас)
- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хуралд оролцсон төлөөлөгчдийн материал-2022.03.10 (хурлын төлөөлөгчдийн анкет, гишүүний батлах, иргэний үнэмлэхний хуулбар-3 хавтас, 1414 хуудас) баримтыг ирүүлсэн байна.
- Гурав.Ч.Өнөрбаяраас 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 49 дугаартай албан бичигт “...нэмэлт материал хүргүүлэх” гээд,
- Үндэсний бодлогын хорооны 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 01 дугаартай “Хуралдаан зохион байгуулсан тухай” тэмдэглэл (9 хуудас),
- Үндэсний бодлогын хорооны хурлын ирцийн мэдээлэл (9 хуудас)
- Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлыг хуралдуулах санал гаргаж хуралдаанд биечлэн болон цахимаар оролцсон Үндэсний бодлогын хорооны гишүүдийн нэрсийн жагсаалт (7 хуудас),
- Хурлын хэлэлцэх асуудлаар санал хураалт явуулсан дүн мэдээ (16 хуудас),
- Дөрөв.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбатаас ирүүлсэн 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 22

дугаартай албан бичигт: “...Үндсэн дүрмийн хүрээнд зөрчлийг арилгах үүднээс намын ээлжит бус XIII Их хурлаа зарлан хуралдуулж, намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг үндсэн дүрэмд заасан журмын дагуу хэлэлцүүлэн батлуулж, бүртгүүлэхээр шийдвэрлэсэн. Түүнчлэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 125 дугаартай тогтоолоор тус намын тамгатай холбоотой маргааныг хэлэлцэн, Ц.Туваан, О.Цогтгэрэл нарын ашиглаж байсан тамга хүчингүй болохыг тогтоон эцэслэн шийдвэрлэж, Ардчилсан намаас үйл ажиллагаагаа цаашид хэвийн явуулах нөхцөл бүрдсэн” гэжээ.

Тав.Б.Ган-Очироос ирүүлсэн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 03/22 дугаартай албан бичигт: “...Улс төрийн зөвлөл 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2/04 дүгээр тогтоолоороо ҮБХ-ны ээлжит бус хурлын товыг мөн оны 03 дугаар сарын 03-ны өдөр товлосон. Дээрх товыг дагуу хуралдсан ҮБХ-ны ээлжит бус хурлын 23/07 дугаар тогтоолоор Ардчилсан намын ээлжит бус Их хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр товлон зарлаж, тус хурлын хэлэлцэх асуудлыг Ардчилсан намын даргыг ёсчлон батламжлах, Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн батлах гэсэн 2 агуулгаар тогтоосон нь үндсэн дүрмийн 5 дугаар бүлийн 5.13.12-т “ҮБХ нь дараах эрх үүрэгтэй байна; 5.13.12.23-т “ээлжит ба ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудлыг тогтоох” гэсэнтэй нийцэж байна. Ардчилсан намын эрх барих дээд байгууллага буюу Их хурал 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хуралдаагүй тул Ардчилсан намын үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлагдсан үйл явдал болоогүй. Үндсэн дүрмийн өөрчлөлтийн төсөл боловсруулж, анхан шатны гишүүдээр хэлэлцүүлэн, зохих байгууллагад өргөн мэдүүлэх бэлтгэлийг ханган, Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооноос Ардчилсан намын даргын сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаа үргэлжилж байна” гэжээ.

Мэдэгдэлдээ: - Улс төрийн зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Үндэсний бодлогын хорооны ээлжит бус хурлын тов тогтоох тухай” 2/04 дугаартай тогтоол (1 хуудас)

- Үндэсний бодлогын хорооны хурлын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Ардчилсан намын ээлжит бус Их хурлын тов, хэлэлцэх асуудал тогтоох тухай” 23/07 дугаартай тогтоол (1 хуудас) хавсарган ирүүлжээ.

Зургаа. Мөн 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Хүсэлт буцаах тухай” 03/24 дугаартай албан бичигт: “...Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Ардчилсан намын үндсэн дүрэмд “намын төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хороог “цахимаар” хуралдуулах, намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг “танхим болон цахим” гэсэн хосолмол хэлбэрээр зохион байгуулах” зохицуулалт огт байдаггүй бөгөөд энэ нь С.Эрдэнэ, Д.Ганбат, Ч.Өнөрбаяр тэргүүтэй хүмүүсийн зохион байгуулсан дээрх хурлууд бүгд хууль бус юм. 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан “ҮБХ-ны цахим хурал” гэгчид Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны гишүүд “Ардчилсан намын VIII Их хурлын 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 389 гишүүн” огт оролцоогүй. Улсын дээд шүүхийн удаа дараагийн тогтоол, шийдвэрээр Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан (дарга)

улсын бүртгэлд өнөөг хүртэл бүртгэгдээгүй байгаа нь “ҮБХ-ны хурлыг намын дарга зарлан хуралдуулна” гэсэн дүрмийн зохицуулалтыг хэрэгжих бололцоогүй болгосон бөгөөд намын Их хурлыг “ҮБХ-ны ердийн олонхи (50-аас дээш хувь)-ийн саналаар зарлан хуралдуулах”-аас өөр дүрмийн боломж байхгүй. Ардчилсан нам дотоод маргаантай асуудлаа Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй үндсэн дүрмийн дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна” гэжээ. (мэдэгдэл 3 хуудас, хавсралт 8 хуудас хэвлэсэн зураг) баримт хавсарган ирүүлжээ.

Долоо.Мөн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн “Шаардлага хүргүүлэх тухай” 03/28 дугаартай албан бичигт “...С.Эрдэнэ нь Ардчилсан намын даргаар улсын бүртгэлд бүртгүүлэхээр удаа дараа хандсан боловч Монгол Улсын дээд шүүх 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 04, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 09, 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзсан. Өөрөөр хэлбэл, С.Эрдэнэ нь Ардчилсан намыг төлөөлөх эрхгүй гэдгийг нотолсон.

Ардчилсан намын дүрмийн дагуу намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь намын Их хурлын бүрэн эрх байх тул ээлжит бус Их хурлаас ажлын хэсэг томилогдох ёстой. Тухайн ээлжит бус Их хурлыг ҮБХ-оос зарлах ба ҮБХ-ны хуралдааныг нийт 389 гишүүний 3/1-ийн шаардлагаар Улс төрийн зөвлөлийг зарлан хуралдуулна. Энэхүү дарааллын дагуу намын ээлжит бус Их хурлаас үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг томилогдож, ажлын хэсгээс боловсруулсан үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг намын бүх шатны байгууллагуудаар хэлэлцүүлж, Үзэл баримтлал, үндсэн дүрмийн зөвлөлөөр хянуулж, намын Их хурлаар батлуулсны дараа улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр ханддаг. С.Эрдэнэ, Д.Ганбат, Ч.Өнөрбаяр нарын Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Ардчилсан намын Үндсэн дүрмийн заалтыг мөрдөөгүй, зөрчигдсөн үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, хэлэлцэх гэж байгааг Ардчилсан намаас хүлээн зөвшөөрөхгүй байна” гэжээ.

#### ҮНДЭСЛЭХ нь:

Ардчилсан намын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаар баталсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг С.Эрдэнэ, Д.Ганбат, Ч.Өнөрбаяр нар гаргасан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг өргөдөл гаргах эрх бүхий этгээд гаргах”-аар, 22 дугаар зүйлийн 22.1.5-д “шаардлагатай тохиолдолд итгэмжлэл”-ийг хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүрдүүлэхээр заасан бөгөөд Ардчилсан намын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаас намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхтэй холбоотой асуудлаар Улсын дээд шүүхэд Ардчилсан намыг төлөөлөн шүүхэд хандах, өргөдөл гаргах эрхийг С.Эрдэнэ, Д.Ганбат, Ч.Өнөрбаяр нарт олгосон байх тул хуулийн дээрх зохицуулалтад нийцжээ.

1.Ардчилсан намын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн IX Их хурлаар намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн баталсныг Улсын дээд шүүхийн 2019

оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгэж баталгаажуулсан байх бөгөөд үүнээс хойш тус намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдлийг Улсын дээд шүүхээс дараах байдлаар шийдвэрлэжээ. Тодруулбал,

- Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгч Ц.Туваанаас өргөдөл гаргасныг, 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор "...намын Их хурлыг хуралдуулахаар зарласан Ц.Туваан намын даргыг төлөөлөх эрхтэй эсэх нь маргаантай, энэ талаар намын дотоод хүрээнд маргаантай асуудал үүссэн байна" гэж,

- Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга П.Нүрээд, Үндсэн дүрмийн хорооны дарга Б.Мягмардаш нараас өргөдөл гаргасныг, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор "...өмнөх шүүхийн тогтоолд заасан зөрчил арилаагүй, хурлыг даргын үүрэг гүйцэтгэгч зарласан нь эрх бүхий этгээд гэж үзэхгүй" гэж,

- Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга А.Цэрэнбатаас өргөдөл гаргасныг, 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор "...Үндэсний бодлогын хороо үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь намын дүрэмд нийцээгүй, намын Их хурлын бүрэн эрхэд хамаарч байна, намын дотоод хүрээнд маргаантай асуудал үүссэн" гэж,

- С.Эрдэнээс өргөдөл гаргасныг, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор "...Ардчилсан намыг төлөөлж өргөдөл гаргах эрх бүхий этгээд гэж үзэх боломжгүй, хуралдааныг хэн хэзээ ямар шийдвэрээр зарласан, хэлэлцэх асуудал, хурлын тов тогтоосон баримт ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичгийн хүрээнд шүүх дүгнэх боломжгүй" гэж,

- Ардчилсан намын тэргүүн дэд дарга Д.Ганбатаас өргөдөл гаргасныг, 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолоор "...Үндэсний бодлогын хороо нь намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй" гэсэн үндэслэлүүдээр тус тус бүртгэхээс татгалзжээ.

2.Энэ тохиолдолд буюу 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр С.Эрдэнэ нараас гаргасан "намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх" өргөдлийг судлахад дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

- Намын үндсэн дүрмийн 9 дүгээр бүлгийн 9.1.1 дэх заалтыг баримтлан Ардчилсан намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тус намын Үзэл баримтлал, Үндсэн дүрмийн зөвлөлөөс санал гаргаж,

- Үндэсний бодлогын хорооны 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг намын ээлжит бус XIII Их хуралд өргөн барьж,

- 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр намын ээлжит бус XIII Их хурлаар үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэн баталжээ.

Ардчилсан намын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаар баталсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь өмнөх шүүхийн

тогтоолуудад заасан “...намын дотоод маргаан шийдэгдээгүй, намын даргыг сонгох сонгуулийн үйл явц нь намын үндсэн дүрмээр зохицуулагдах тус намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой маргаан” гэх үндэслэлд хамааралгүй байгаа тул бүртгэх боломжтой гэж үзлээ.

Энэхүү үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг өмнө нь Үндэсний бодлогын хороо баталсныг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн, улмаар энэхүү татгалзсан зөрчлийг арилгаж, намын ээлжит бус XIII Их хурлаар үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлж батлуулсан нь Ардчилсан намын үндсэн дүрмийн 5.12.4.1-д “Намын Үзэл баримтлал, үндсэн дүрэм, бусад журам, мөрийн хөтөлбөрийг намын Их хурал батлах”, 9.1.1-д “Намын Үзэл баримтлал, үндсэн дүрэм, бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгын санал боловсруулах, Их хуралд өргөн барьж, хэлэлцүүлэх асуудлыг ҮБХ-ны Үзэл баримтлал, Үндсэн дүрмийн зөвлөлийн саналд үндэслэн ҮБХ-ноос намын Их хуралд өргөн барина” гэж заасанд нийцжээ.

Түүнчлэн, энэ удаагийн өргөдөлд заасан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь Ардчилсан намын дотоодод үүсээд байгаа намын даргын маргаантай хамааралгүй, өмнө ирүүлсэн өргөдлүүдээс ялгаатай байна. Энэ тохиолдолд “Ардчилсан намын даргын бүртгэл”-тэй холбоотой ямар нэгэн өргөдөл гаргаагүй, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан өргөдөлд тусгагдаагүй “намын даргын бүртгэл”-ийн асуудлыг шийдвэрлээгүй болно.

3.Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоолоор тус намын үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг судалж үзвэл:

- 3 дугаар бүлгийн 3.1.2-т “Намд гишүүнээр элсэхийг хүссэн иргэн байнга оршин суугаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх анхан эсвэл дунд шатны байгууллагад хүсэлтээ журмаар батлагдсан маягтын дагуу гаргана”,

- 3.1.6-д “Намын дарга, Үндэсний бодлогын хороо (цаашид “ҮБХ” гэнэ), Үндсэн дүрмийн хороо (цаашид “ҮДХ” гэнэ), Улс төрийн зөвлөл (цаашид “УТЗ” гэнэ), Дотоод сонгуулийн хороо (цаашид “ДоСХ” гэнэ)-ны гишүүний бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тусгайлан журмаар зохицуулна”,

3.7.6-д “Намын дотоод асуудлаар намын нэр хүнд, эв нэгдэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх олон нийтэд хандсан үйлдэл хийхгүй байх, намын дотоод мэдээллийг бусдад задруулахгүй байх, намын удирдах болон улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан гишүүд намын байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн намын өмнөөс үйл ажиллагаа явуулахгүй байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн цахим сүлжээ ашиглан мэдэгдэл, мэдээлэл хийхгүй байх”,

3.8.1-д “Намын байгууллага нь гишүүнээ Монгол улсын цол хүртээх, төрийн дээд одон медаль болон Засгийн газрын шагналаар шагнуулахаар тодорхойлж болно”.

3.9.1.5-д “Намын тамга тэмдэг, гишүүний батлах хадгалах, хэрэглэхтэй холбоотой журмыг санаатайгаар болон зохион байгуулалттайгаар зөрчсөн”,

3.9.1.13-т “Гишүүний бүртгэл, татвар, хураамжийн төлөлттэй холбогдох журмыг санаатайгаар болон зохион байгуулалттайгаар зөрчсөн”,

3.10.1.1-д “Сонгуулийн үр дүнгээр намын дарга, дэд дарга болон намын ЕНБД-д хариуцлага тооцож итгэл үзүүлэх эсэх асуудлыг ҮБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж болно”.

3.10.1.2-т “Намын Үндэсний бодлогын хороо (цаашид “ҮБХ” гэнэ) нь Үндсэн дүрмийн 3.10.1.1 дэх хэсэгт заасан асуудлаар УИХ-ын сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хуралдаж, шийдвэрийг 5 хоногт багтаан гаргана”,

3.10.2.1-д “Сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэл, дүүргийн намын дарга, дэд дарга, ХЭГ-ын дарга нарт хариуцлага тооцож итгэл үзүүлэх эсэх асуудлыг тухайн шатны намын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж болно”.

3.10.2.2-т “Намын Хороо нь үндсэн дүрмийн 3.10.2.1 дэх хэсэгт заасан асуудлаар аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хуралдаж, шийдвэрийг 5 хоногт багтаан гаргана”,

5 дугаар бүлгийн 5.5.1-д “Намын дарга, ҮБХ-ны дарга, дэд дарга, ЕНБД”,

5.10.23.16.1-д “Үндсэн дүрмийн 3.10.2.2 дахь хэсэгт заасны дагуу тухай шатны намын хорооны хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр болсон”,

5.11.17.1-д “Үндсэн дүрмийн 3.10.2.2 дахь хэсэгт заасны дагуу тухай шатны намын хорооны хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр болсон”,

5.13.1-д “Намын төлөөллийн төв байгууллага буюу хуульд зааснаар намын эрх бүхий байгууллага нь Үндэсний бодлогын хороо мөн”,

5.13.13.1-д “Намын дарга эсвэл ҮБХ-ны дарга нь ҮБХ-ны 1/3-ээс доошгүй гишүүдийн шаардлагаар 14 хоногоос хэтрүүлэлгүйгээр зарлан хуралдуулах үүрэгтэй”,

5.13.2-т “Үндэсний бодлогын хороо нь үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн мандатын тоог 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү тооны гишүүдтэй байна”,

5.13.8-д “ҮБХ-ны гишүүний суудлын тоог өөрчлөх саналыг дараах тохиолдолд ДоСХ-ноос ҮБХ-ны дарга, намын даргатай зөвшилцөн ҮБХ-нд оруулж хэлэлцүүлж болно”,

5.13.10-т “ҮБХ-ны ээлжит хурлыг намын дарга, ҮБХ-ны дарга эсхүл УТЗ-өөс зарлана”,

5.13.11-д “ҮБХ-ны гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ ҮБХ-ны дарга, ДоСХ-нд бичгээр гаргана”,

5.13.12.2-т “ҮБХ нь УИХ-ын байнгын хороодтой тэнцүү, тэдгээрийн эрхлэх асуудлаар намын улс төрийн бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий бодлогын зөвлөлүүдийг зохион байгуулж ажиллуулах”,

5.14.1-д “Бодлогын зөвлөл (цаашид “БЗ” гэх) нь Монгол Улсын Их Хурлын байнгын хороодын эрхлэх ажлын чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах бөгөөд ҮБХ-ны гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна”,

5.14.3-т “ҮБХ-ны гишүүн нь өөрийн саналаар нэг бодлогын зөвлөлд харьяалагдан ажиллах ба зөвлөлийн бүрэлдэхүүнийг ҮБХ баталгаажуулна”,

5.14.7.3-т “Намын хүний нөөцийн бүртгэл хөтлөх, албан томилгооны асуудлаар Намын дарга, ҮБХ-ны дарга, УТЗ-д зөвлөмж хүргүүлэх”

5.15.2-т “Намын дарга нь УТЗ-ийн хурлын товыг зарлах, хэлэлцэх асуудлыг батлах, улс төрийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, хурлыг даргалах эрх, үүрэгтэй”,

5.15.13-т “УТЗ нь тухайн үеийн Засгийн газрын гишүүдийн тоотой тэнцүү тооны гишүүдээс бүрдэх бөгөөд ҮБХ-оос сонгогдож, томилогдоно.

Улс төрийн зөвлөл нь Засгийн газрын кабинетын зарчмаар үйл ажиллагаагаа зохион байгуулна”,

5.17.6-д “Намын даргыг дараах үндэслэлээр ҮБХ-ны хурлаар чөлөөлж намын Их хурлыг зарлана. Энэ тохиолдолд чөлөөлөгдсөн намын дарга нь АН-ын үндсэн дүрмийн 5 дугаар бүлгийн 5.12.4.8 дахь хэсэгт заасны дагуу батламжлагдаж, шинээр сонгогдсон намын даргад эрх үүргээ шилжүүлснээр бүрэн эрх нь дуусгавар болно”

5.17.6.1-д “Үндсэн дүрмийн 3.10.1.1 дэх хэсэгт заасны дагуу ҮБХ-ны шийдвэр хүчин төгөлдөр болсон”,

5.17.7-д “Ардчилсан намын дарга, ҮБХ-ны дарга, дэд дарга, ЕНБД, Нийслэлийн намын дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр Ардчилсан намын удирдлага буюу Намын даргын зөвлөлийг байгуулна. Намын даргын зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа хуралдана”,

6 дугаар бүлгийн 6.3-т “УИХ дахь бүлгийн хуралд ҮБХ-ны дарга, намын ЕНБД таслах эрхгүй оролцоно” гэсэн заалтуудыг тус тус өөрчлөн найруулж,

Намын дүрэмд 5 дугаар бүлгийн 5.13.1.1-д “Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг намын эрх бүхий байгууллага буюу Үндэсний бодлогын хороо шийдвэрлэнэ”,

5.13.12.27.16-д “ҮБХ-ны хурлаар ҮБХ-ны дарга, тэргүүлэгчдийг сонгох, тэдний эрх, үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг батална”,

5.13.12.27.17-д “УТЗ-ийн бүрэлдэхүүнийг намын даргын санал болгосноор ҮБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна. ҮБХ нь УТЗ-ийн бүрэлдэхүүний эрх үүрэг, үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина”,

5.13.14-т “ҮБХ-ны хурлын бүрэн эрхийн хугацаанд ҮБХ-ны гишүүдээс 5 гишүүний бүрэлдэхүүнтэй Хурлын тэргүүлэгчдийг сонгож ажиллуулна. Тэргүүлэгчдийн хурлаас ҮБХ-ны даргыг сонгож ажиллуулна”,



5.13.15-д “ҮБХ-ны хурлын Тэргүүлэгчид нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ;

5.13.15.1-д “Бодлогын зөвлөлүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх”,

5.13.15.2-т “ҮБХ-ны байнгын үйл ажиллагааг хангах, намын бодлогыг оновчтой тодорхойлох, үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор намын төлөөллийн төв байгууллагын үйл ажиллагааг чадавхжуулж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажиллах”,

5.13.12.29-д “Улсын Их хурлын даргад ҮБХ-ны даргыг 4 жилийн хугацаатай нэр дэвшүүлэх”,

5.18.3-т “Намын даргаас үндсэн дүрмийн 5 дугаар бүлгийн 5.17.4.3 дахь заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд Тэргүүн дэд даргыг ҮБХ-нд санал болгосноор томилж, чөлөөлж болно. Тэргүүн дэд дарга нь намын үндсэн дүрэмд заасан дэд даргын адил эрх, үүрэгтэй байна” гэснийг тус тус шинээр нэмсэн байна.

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана” гэж заасан бөгөөд энэ тохиолдолд Ардчилсан намын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус XIII Их хурлаар баталсан дээрх намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн агуулга нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчөөгүй байна.

Иймээс Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн олонхи үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1.Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 22 дугаар зүйлийн 22.1.4-т заасныг баримтлан Ардчилсан намын ээлжит бус XIII Их хурлын 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоолоор баталсан Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсүгэй.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ